



Хүнсний гол нэрийн барааны үнэ


2019 оны 5-р сарын 15-ны байдлаар

2019 оны 5-р сарын 15-ны байдлаар гол нэрийн барааны үнийг өмнөх сартай харьцуулахад 10.7 хувь, өмнөх 7 хоногтой харьцуулахад 10.6 хувиар өссөн байна.

Махны дундаж үнэ: 2019 оны 5-р сарын 15-ны байдлаар ямааны ястай махны үнэ 37.5 хувь, адууны ястай махны үнэ 36.7 хувь, үхрийн ястай махны үнэ 23.6 хувь, хонины ястай махны үнэ 22.4 хувь, үхрийн цул махны үнэ 21.9 хувиар байна.

Өмнөх 7 хоногтой харьцуулахад ямааны ястай махны үнэ 37.5 хувь, адууны ястай махны үнэ 36.2 хувь, үхрийн ястай махны үнэ 24.1 хувь, үхрийн цул махны үнэ 21.9 хувь, хонины ястай махны үнэ 21.8 хувиар өссөн байна.

Зураг 1. Ястай махны жижиглэн худалдааны дундаж үнэ, төгрөг




2019 оны 5-р сарын 15-ны байдлаар 1 кг үхрийн цул мах 14383 төгрөг, үхрийн /ястай/ мах 11912 төгрөг, хонины /ястай/ мах дунджаар 10 658 төгрөг, адууны /ястай/ мах 9188 төгрөг, ямааны /ястай/ мах 8800 төгрөгийн үнэтэй байв (Зураг 1).

Гурилын үнэ: 2019 оны 5-р сарын 15-ны байдлаар гурилын үнэ өмнөх сараас дээдийн дээд зэргийн савласан гурилын үнэ 1.7 хувь, 1-р зэргийн савласан гурилын үнэ 0.5 хувиар буурсан бол дээд зэргийн савласан гурилын үнэ 0.5 хувиар өссөн байна. Өмнөх 7 хоногоос дээдийн дээд зэргийн савласан гурилын үнэ 3.1 хувь, 1-р зэргийн савласан гурилын үнэ 0.5 хувь, дээд зэргийн савласан гурилын үнэ 0.2 хувиар буурсан бол 2-р зэргийн савласан гурилын үнэ 0.5 хувиар өссөн байна.

Будаа, элсэн чихрийн дундаж үнэ: 2019 оны 5-р сарын 15-ны байдлаар цагаан будааны үнэ өмнөх сараас 1.1 хувь, өмнөх 7 хоногоос 0.5 хувиар өссөн байна. Элсэн чихрийн үнэ өмнөх сараас 1.0 хувь, өмнөх 7 хоногоос 0.4 хувиар буурсан байна. (Зураг2).

Зураг 2. Цагаан будаа, элсэн чихэр, төмсний дундаж үнэ, төгрөг



Төмс, хүнсний ногооны дундаж үнэ: 2019 оны 5-р сарын 15-ны байдлаар төмс, хүнсний ногооны үнийг өмнөх сарын дундаж үнэтэй харьцуулахад байцааны үнэ 25.7 хувь, луувангийн үнэ 7.7 хувь, сонгины үнэ 5.2 хувь, хүрэн манжингийн үнэ 4.5 хувь, төмсний үнэ 3.8 хувиар өссөн байна.

Өмнөх 7 хоногоос байцааны үнэ 20.0 хувь, луувангийн үнэ 6.0 хувь, сонгины үнэ 5.2 хувь, төмсний үнэ 1.8 хувь, хүрэн манжингийн үнэ 1.4 хувиар өссөн байна.

Сүү, өндөг, ургамлын болон цөцгийн тосны дундаж үнэ: 2019 оны 5-р сарын 15-ны байдлаар өмнөх сараас задгай сүүний үнэ 6.1 хувь, савласан /1 литрийн/ сүүний үнэ 1.2 хувь, “элекстер” /0.5 литрийн/ сүүний үнэ 1.0 хувиар буурсан байна. Өмнөх 7 хоногоос “элекстер” /0.5 литрийн/ сүүний үнэ 0.9 хувь, савласан /1 литрийн/ сүүний үнэ 0.3 хувиар буурсан бол задгай сүүний үнэ өөрчлөлтгүй байна.

Цөцгийн тосны үнэ өмнөх сар болон өмнөх 7 хоногоос өөрчлөлтгүй байна. Ургамлын тосны үнэ өмнөх сараас 0.8 хувь, өмнөх 7 хоногоос 0.6 хувиар өссөн. Өндөгний үнэ өмнөх сараас 1.5 хувь, өмнөх 7 хоногоос 0.1 хувиар өссөн байна.

**ҮСХ-ны Эдийн засгийн статистикийн газар
2019 оны 5-р сарын 15**